

2025 он 03 сар 20 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

**Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний мэдээлэлд  
өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.7.1 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэр дурдсан үйл ажиллагааны үндсэн чиглэлээс 5510 кодтой “Зочид буудал”-ын үйл ажиллагааг хассугай.
2. Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн өөрчлөлтийг хууль тогтоомжийн дагуу Улсын бүртгэлийн байгууллагад итгэмжлэлгүйгээр төлөөлөн бүртгүүлэхийг Хуулийн хэлтсийн дарга /Ц.Цасчихэр/-т даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



*[Handwritten signature]*

Ц.БААТАРСАЙХАН

*[Handwritten signature]*

Б.АМАРСАЙХАН

*[Handwritten signature]*

Д.ГЭРЭЛМАА

*[Handwritten signature]*

А.ЖАРГАЛМАА

*[Handwritten signature]*

Н.МӨНХБАТ

*[Handwritten signature]*

Ц.ОРГИЛБОЛД

*[Handwritten signature]*

Д.ХУЛАН

*[Handwritten signature]*

Д.ХҮРЭЛБААТАР

*[Handwritten signature]*

Б.ЦЭЭНЯМ

**2025 онд сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийгдэх хэлцэлд зөвшөөрөл олгох тухай**

Говь ХК-ийн 2025 онд сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийгдэх хэлцлийг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.7.15 дахь заалт, Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмын 3 дугаар зүйлийн 3.3.1.1 дэх заалтыг тус тус удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Говь ХК нь 2025 онд компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бараа, үйлчилгээг зах зээлийн үнэ, нөхцөлөөр худалдан авах болон худалдах, зээлийн шугамын гэрээ байгуулахыг зөвшөөрсөн сонирхлын зөрчилтэй буюу нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалтыг Хавсралт 1-ээр баталсугай.
2. 2025 онд Нэгдмэл сонирхолтой этгээдүүдтэй хийх сонирхлын зөрчилтэй хэлцлийн төсвийг Хавсралт 2-оор баталсугай.
3. Хавсралт 1-д заагаагүй сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх болон Хавсралт 2-д баталсан төсвөөс хэтэрсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тохиолдолд тухай бүр Төлөөлөн Удирдах Зөвлөлд мэдэгдэж, Компанийн тухай хуулийн 76.1.17, 92 дугаар зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл авч байхыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д үүрэг болгосугай.
4. Дээрх сонирхлын зөрчил бүхий этгээдүүдтэй хийгдэх хэлцэл нь батлагдсан төсвийн хүрээнд, зах зээлийн үнээр, хуулийн дагуу хийгдэж байгаа эсэх дээр улирал бүрийн хорооны хурлаар дамжуулан хяналт тавьж ажиллахыг Эрсдэл, аудитын хорооны дарга /А.Жаргалмаа/-д үүрэг болгосугай.
5. Жилийн эцэст сонирхлын зөрчил бүхий этгээдүүдтэй хийгдсэн ажил гүйлгээний гүйцэтгэлийг гарган, зах зээлийн үнийн харьцуулсан судалгааны хамт Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д үүрэг болгосугай.
6. Энэхүү асуудлыг сонирхлын зөрчилгүй Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:



*(Handwritten signatures)*

Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Д.ХҮРЭЛБААТАР

Б.ЦЭЭНЯМ

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2025 он 03 сарын 20-ны өдрийн хурлын  
07-р тогтоолын 1-р хавсралт



2025 онд бараа, үйлчилгээг зах зээлийн үнээр худалдан авах, худалдах,  
зээлийн шугамын гэрээ байгуулахыг зөвшөөрсөн сонирхлын зөрчилтэй буюу  
нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн жагсаалт

#### 1. Таван Богд Группийн охин компаниуд

Д/д	Компанийн нэрс	Д/д	Компанийн нэрс
1	Таван Богд Холдингс ХХК	11	Улаанбаатар Принт ХХК
2	Таван Богд Интернэйшнл ХХК	12	Таван Богд Фүүд Сервис ХХК
3	Таван Богд Дистрибьюшн ХХК	13	Таван Богд Нура ХХК
4	Таван Богд ХХК	14	Таван Богд Проперти ХХК
5	Эйрлинк Монголиа ХХК	15	Таван Богд Финанс ББСБ ХХК
6	Улаанбаатар Гурил ХХК	16	Таван Богд Капитал ҮЦК ХХК
7	Жуулчин ХХК	17	Таван Богд Билдинг Саплай ХХК
8	Хаан Палас ХХК	18	Таван Богд Моторс ХХК
9	Таван Богд Фүүдс ХХК	19	Жуулчин Дюти Фрий ХК
10	Таван Богд Фүүдс Пицца ХХК	20	Таванбогд Констракшн Машинери ХХК

#### 2. Таван Богд Группийн хөрөнгө оруулалттай компаниуд

Д/д	Компанийн нэрс	Д/д	Компанийн нэрс
1	Хаан Банк ХК		

#### 3. Бусад холбоотой талууд

Д/д	Компанийн нэрс	Д/д	Хувь хүмүүсийн нэрс
1	Ар И Ди Эженси ХХК	1	Ц.Оюунжав /ПБ62013022/
2	Глобал Бридж ХХК	2	Ц.Оюунсүрэн /УС67112700/
		3	Ц.Оюунбилэг /ПБ82100704/

#### 4. Говь ХК-ийн охин компани, салбарууд

Д/д	Охин компанийн нэрс	Д/д	Охин компани, салбарын нэрс
1	Гоёо ХХК	5	Говь Кашмер Их Британи ХХК
2	Говь Кашмер Европ ХХК	6	Говь Кашмер Казахстан ХХК
3	Говь Кашмер Өвөр Монгол ХХК	7	Говь Австрали /салбар/
4	Говь Кашмер Америк ХХК		

**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг  
шинэчлэн батлах тухай**

Говь ХК-ийн хэмжээнд баримтлах нягтлан бодох бүртгэлийн бодлогыг шинэчлэн батлах тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.7.11 дэх заалтыг удирдлага болгон Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Говь ХК-ийн “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг Хавсралт 1-ээр баталсугай.
2. Энэхүү бодлогыг баталсантай холбоотой Гүйцэтгэх захирлын 2021 оны 12-р сарын 17-ны өдрийн А/50 тоот тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг хүчингүйд тооцсугай.
3. Шинэчлэн батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/, Бүртгэлийн газрын захирал /Д.Содгэрэл/ нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БААТАРСАЙХАН

20~~25~~<sup>26</sup> он 03 сар ~~20~~<sup>21</sup> өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

**ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай**

Говь ХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсонтой холбоотой ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2 дахь заалт, 81 дүгээр зүйлийн 81.1, 81.2 дахь заалт, Говь ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.2.20, 6.2.21 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**


1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг Хавсралт 1-ээр шинэчлэн томилсугай.
2. Шинээр томилогдсон хороодын дарга, гишүүдэд Компанийн тухай хууль, Говь ХК-ийн дүрэм болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, ажиллахыг үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ц.БААТАРСАЙХАН

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2025 оны 03 сарын 20-ны өдрийн хурлын  
09-р тогтоолын 1-р хавсралт



ГОВЬ ХК-ИЙН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН

Хороод		Бүрэлдэхүүн	
Нэр дэвшүүлэх хороо	дарга	хараат бус гишүүн	Д.Гэрэлмаа
	гишүүн	хараат бус гишүүн	Д.Хүрэлбаатар
	гишүүн	ердийн гишүүн	Ц.Баатарсайхан
Цалин урамшууллын хороо	дарга	хараат бус гишүүн	Д.Хүрэлбаатар
	гишүүн	хараат бус гишүүн	Б.Цээням
	гишүүн	ердийн гишүүн	Д.Хулан
Эрсдэл, аудитын хороо	дарга	хараат бус гишүүн	А.Жаргалмаа
	гишүүн	хараат бус гишүүн	Д.Гэрэлмаа
	гишүүн	ердийн гишүүн	Н.Мөнхбат